

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ҮР ДҮН

*Монгол Улсын ШУА-ийн ОУХХ-ийн секторын эрхлэгч,
доктор (Sc,D), профессор А.Даваасүрэн
Email: davaasuren13@yahoo.com*

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн шилжилтийг эхлүүлсэн 28 жилийн хугацаанд гадаад худалдаа, үнэ тариф болон үндэсний мөнгөний нэгжийн гадаад валюттай харьцах ханшийг чөлөөлөх, төрийн өмчийг хувьчлах, зах зээлийн эдийн засгийн суурь болсон төрийн интитуциудыг байгуулах, улс төр, эдийн засаг, нийгмийн бүх хүрээг хамарсан бүтцийн өөрчлөлт, шинэчлэлүүдийг хийх эхний үе шатанд багагүй амжилт олсоныг үгүйсгэхгүй. Гэвч тухайн үед төр засгаас авч хэрэгжүүлсэн хэтэрхий нээлттэй, чөлөөтэй зах зээлийн бодлого хэрэгжүүлсний улмаас үндэсний боловсруулах аж үйлдвэрүүдийг үндсэн нь устгаж, манай улсын эдийн засаг гадаад зах зээл, байгаль цаг агаарын нөхцлөөс ихээхэн хамааралтай болж нийгэмд ажилгүйдэл, ядуурал гэсэн шинэ үзэгдэл бий болсон. Тухайлбал, 1990 оноос өмнө Монгол Улсын ДНБ-д боловсруулах салбарын эзлэх хувийн жин 35,6 хувийг эзлэж, өөрөөр хэлбэл дотоодын боловсруулах үйлдвэрүүдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний 1/3 бид өөрсдөө үйлдвэрлэж байжээ. Тэгвэл өнөөдөр энэ салбар ДНБ-ий дөнгөж 9 хувийг үйлдвэрлэж байна.

Зах зээлийн эдийн засгийн тогтолцоо руу шилжилтийг хэрэгжүүлэх явцад бид дэлхийн санхүү, эдийн засгийн хоёр ч удаагийн хүчтэй хямралтай тулгарч манай улсын эдийн засгийн дархлаа улам муудаж, эдийн засгийн салбар хоорондын тэнцвэр алдагдаж, үндэсний валют болох төгрөгийн ханш байнга унаж, эрдэлтэй эмзэг байдал

улам нэмэгдсээр байна. Монгол улсад аж ахуйн нэгж байгууллага, боловсруулах үйлдвэрүүдийн технологийн хэлхээ холбоос тасарсанаар эдийн засгийн салбаруудын хоорондын бодлогын уялдаа алдагдаж, эдийн засгийн суурь болсон уламжлалт мал аж ахуй болон газар тариаланг хөгжүүлэхэд цаг агаарын өөрчлөлт сөргөөр нөлөөлж ирсэн байдаг. Хэдийгээр төр, засгийн байгууллагуудын зүгээс эдийн засгийн ээлжит хүндрэлийг даван туулахад шаардлагатай бодлого зохицуулалтын арга хэмжээг авч байсан боловч тэдгээр нь төдийлөн үр дүнд хүрч чадахгүй явж иржээ. Энэ нь төрийн эдийн засгийн бодлого, зохицуулалт нь залгамж шинж чанаргүй, Монгол Улсын хууль эрх зүйн орчин тогтворгүй, гадаадын хөрөнгө оруулагчдад ойлгомжгүй, тодорхой бус байдлыг үүсгэж байсантай холбоотой гэж үзэж байна. Тухайлбал, маш богино хугацаанд хамгийн их засвар орсон гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг нэрлэж болно. Монгол Улсын макроэдийн засгийн нөхцөл байдлыг хүснэгт 1;2-оос харна уу.

Хүснэгт 1. Монгол Улсын макроэдийн засгийн зарим үзүүлэлтүүд
(Оны үнээр, төгрөг)

Он	ДНБ-ний өсөлт хувиар	1 хүнд ногдох ҮНО-ын хэмжээ доллар	ДНБ-ний хэмжээ тэрбум төг	ДНБ-ний хэмжээ тэрбум доллар	Инфляц, хувиар	Гадаад валютын дундаж ханш төгрөг
2013	11,6	4658	19174,2	12549,7	12,5	1525,7
2014	7,8	4643	22227,0	12197,2	11,0	1818,3
2015	2,4	4218	23150,3	11753,8	-5,5	1970,7
2016	1,0	3857	23886,4	9773,4	1,1	2147,7
2017	5,1	2430	27160,6	11130,7	7,6	2456,8

Эх үүсвэр: Монгол банкны мэдээллийн нэгдсэн сайт, <https://www.mongolbank.mn/> Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <https://www.nso.mn>

Хүснэгт 1-ээс харахад 2013-2016 оны хооронд макроэдийн

засгийн гол үзүүлэлтүүд бүхэлдээ муудсан байна. Тухайлбал, манай улсын эдийн засгийн өсөлт маш тогтворгүй, хэдийгээр нэрлэсэн ДНБ-ний хэмжээ өсөж байгаа мэт харагдавч өндөр инфляци болон төгрөгийн ханш тогтмол уналтаас болж 1 хүнд ногдох бодит орлого жил тутам буурсаар байна. Харин 2017 оноос эдийн засаг бага зэрэг сэргэх хандлага ажиглагдаж байгаа нь урд хөрш БНХАУ-д нүүрс, төмрийн хүдрийн эрэлт нэмэгдсэнтэй холбоотойгоос гадна манай экспортын зарим нэрийн бараа болох алт, зэсийн дэлхийн зах зээлийн үнэ бага зэрэг өссөнтэй холбож ойлгохоос биш засгийн газрын нүдэнд үзэгдэж гарт баригдахаар арга хэмжээ аваагүй, идэвхигүй, үрэлгэн байдлыг зөвтгөмөөргүй байна.

Хүснэгт 2. Монгол Улсын макроэдийн засгийн зарим үзүүлэлтүүд
(Оны үнээр)

Он	Гадаад валютын нөөц, сая доллар	Малын тоо, сая толгой	ДНБ-д эзлэх Засгийн газрын өрийн хувь	ДНБ-д эзлэх нэгдсэн төсвийн алдагдлын хувь	Гадаад худалдааны алдагдал сая доллар
2013	2248,0	45144,3	...	-0,9	-2088,7
2014	1649,9	51982,5	44,2	-4,0	538,0
2015	1323,1	55979,8	52,3	-5,0	871,8
2016	1296,3	61549,2	78,8	-15,4	1331,0
2017	3008,1	66215,8	74,4	-9,9	1865,1

Эх үүсвэр: Монгол банкны мэдээллийн нэгдсэн сайт, <https://www.mongolbank.mn/> Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <https://www.nso.mn>

Хүснэгт 2-оос харахад 2017 онд Монгол Улсын гадаад валютын албан нөөц, малын тоо толгой, гадаад худалдааны эргэлт зэрэг үзүүлэлтүүд эерэг гарсан байна. Тухайлбал, цаг агаарын тааламжтай нөхцөл нь малын тоо толгой өсгөхөд эерэгээр нөлөөлж 2017 онд 66 сая мал тоолуулсан байна. Гэвч мал сүргийн бүтцэд ямаа 45,5 хувь, хонь

41,3 хувь, үхэр 6,6 хувь, адуу 5,9 хувь, тэмээ 0,7 хувийг эзлэж байгаа нь өөрөөр хэлбэл монгол малын 86,9 хувийг бог мал давамгайлж байгаа нь махны гарц, ашиг шим маш бага байхын дээр малын гоц халдварт өвчин байнга гарч байгаа нь монгол малын мах гадаадын худалдан авагчдын сонирхолыг татахгүй байна. Ийм байдал нь мал сүрэг нь улс орны эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөг бий болгож чадахгүй гэж үзэж байна.

Гэвч ДНБ-д эзлэх засгийн газрын өрийн хэмжээ, ДНБ-д эзлэх төсвийн алдагдалын хэмжээ зохистой түвшингээс хол даваж аюулын хэмжээнд хүрээд байна. Тухайлбал, Засгийн газар эдийн засгийн хүндрэлийг даван туулахын тулд худалдан авалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийг урамшуулах зорилгоор ДНБ-д эзлэж гадаад өрийн хэмжээг 60 хувийн зохистой түвшингээс хэтрүүлэн 74,4 хувь болгон нэмэгдүүлж байгаа нь улсын төсөвт ирэх дарамтыг нэмэгдүүлж улмаар улс орны санхүү, эдийн засгийн тогтвортой байдал, эдийн засгийн тасралтгүй нөхөн үйлдвэрлэлийг санхүүгийн нөөцөөр хангах, эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг эрсдэлийг авч ирэхээр байна.

Түүнчлэн Засгийн газар дотоод зах зээл дээр бонд гаргаж хөрөнгө босгож (ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын хэмжээ 3 хувьтай тэнцүү байх ёстой хэмжээг 9,9 хувь болгон нэмэгдүүлж) эдийн засгийн эрэлтийг урамшуулж байгааг цаг үеэ олоогүй, оновчгүй арга хэмжээ гэж үзэхээр байна. Учир нь энэ арга хэмжээний үр дүнд дотоод өрийн хэмжээ нэмэгдэж, төсвийн үр ашиггүй зардлын хэмжээ нэмэгдэж, дотоодын зээлийн хүүг өсгөх аюул бий болохоор байна.

Монгол Улсын гадаад худалдаа байнгын алдагдалтай гарч байсан бол 2014 оноос хойш ашигтай гарах болсон нь Оюутолгой компаний зэсийн баяжмалыг экспортлох болсонтой холбоотой юм. Гэвч Оюутолгой компаний зэсийн баяжмалын биет хэмжээ зөвхөн гаалийн статистикт бүртгэгдэж үлдэж манай улсын банк санхүүгийн байгууллагын дансаар дамжихгүй байгаа нь үндэсний эдийн засагт ямарч дэмжлэг үзүүлэхгүй байна.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн шилжилтийг буруу зохион байгуулсаны үр дүнд 1990 оноос өмнө бүтээн босгосон аж үйлдвэрийн салбар сүйрч, ядуурал хүн амынх нь 1/3-г хамарсан,

хүн амын дотор ядуу хоосоны ялгаа эрс нэмэгдсэн, бүх ард түмэн өр зээлэнд баригдсан нь Монгол Улс анхнаасаа зах зээлийн эдийн засагт шилжихдээ “мордохын хазгай” болсонтой холбоотой гэж үзэхээр байна. Үүний хамгийн эхний учир шалтгаан нь шилжилтийн онолын үзэл баримтлал буруу, хөгжлийн бодлого нь судалгаа шинжилгээнд сайтар үндэслээгүй, үндэсний эдийн засгийн онцлог, ард түмний язгуур эрх ашгаа тэргүүн зэрэгт тавиагүй, өөрийн орны онцлогт тохирсон дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлж чадаагүйтэй холбоотой байна.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжихдээ Дэлхийн банк, ОУВС болон АНУ-ын санхүү, эдийн засгийн онолч Жон Уильямсоноор удирдуулсан хэсэг эрдэмтдийн зөвлөсөн “цочир эмчилгээ” гэж алдаршсан аргыг ашигласан байдаг.

Монгол Улсад “цочир эмчилгээний” загварын үр дүнд үндэсний боловсруулах үйлдвэр, аж ахуйн газруудын хувьчлалыг ямарч бодлогогүйгээр явуулж, хувьчлан авсан эзэд нь тэдгээрийг огт ажиллуулж чадаагүй, олон зуун үйлдвэр, үйлчилгээний болон аж ахуйн газрууд хаалгаа барьж, олон мянган ажилчдыг гудамжинд гаргаж, ажилгүйчүүдийн тоог эрс нэмэгдүүлэх замаар өнөөгийн ажилгүйдэл, ядуурлыг суурийг тавьсан гэж үзэж байна.

Энэ тухай АНУ-ын Колумбын их сургуулийн профессор, 2001 оны эдийн засгийн салбарын Нобелийн шагнал хүртсэн Жозеф Е. Стиглиц “Даяаршил ба түүний бухимдуулалт” номондоо “ажилгүйдэл, ядуурал нь ОУВС-ийн гаднаас нь тухайн улсын төр, засгийг дарамталж, хилийн чандаас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн юм. Өнөөдөр аль нэг улс орныг атомын бөмбөгөөр бөмбөгдөн устгах хэрэггүй болжээ. Учир нь үүнээс илүү үр дүнтэй, хохирол багатай, илүү боловсронгуй колончлолын шинэ хэлбэр, технологийг олжээ. Энэхүү неолиберал бодлогыг хэрэгжүүлэгч институт ОУВС, Дэлхийн банк” гэж дүгнэсэн байдаг¹.

Неолиберал онолын дагуу Монгол Улс зах зээлээ чөлөөтэй нээж, 1996 оноос импортын татварыг тэглэсэн нь үндэсний үйлдвэрлэл дахин сэхэхээргүй цохилтонд орж, Монголын зах зээлийг импортын

чанаргүй, хямд хүнс, өргөн хэрэглээний бараагаар дүүргэж, импортын бараанд дөнгөж 5 хувийн татвар ногдуулахаар болсон нь үндэсний үйлдвэрлэлийг дампууруулж, эдийн засгийг гадаад зах зээлээс хамааралтай болгож, ажилгүйдэл ядууралд ташуур өгсөн гэж эрдэмтэн, судлаачид үздэг. Монгол Улсын нийгмийн зарим үзүүлэлтүүдийг хүснэгт 3-аас харна уу.

Хүснэгт 3. Монгол Улсын нийгмийн зарим үзүүлэлтүүд

	1995	2002	2008	2014	2015	2016	2017
Хүн амын тоо, сая	2248,8	2475,4	2683,5	2995,9	3057,8	3119,9	3177,8
Эрэгтэйчүүдийн тоо, сая	1117,7	1228,1	1309,9	1466,4	1503,6	1534,0	1,562,3
Эмэгтэйчүүдийн тоо, сая	1131,1	1247,3	1373,6	1529,5	1554,2	1585,9	1615,5
Ажилгүйдлийн түвшин %	5,4	3,4	9,0	7,4	7,5	10,0	7,3
Ядуурлын түвшин %	36,3	36,1	35,2	21,6	21,0	29,6	--

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <https://www.nso.mn>

Хүснэгт 3-аас харахад манай улсын хүн амын тоо жил тутам 2 хувиар өсөж байна. Гэвч хүйсний харьцааг авч үзвэл 1994 оноос хойш эмэгтэйчүүдийн тоо нь эрэгтэйчүүдийн тооноос 30-40 мянгаар илүү болж байна.

Монгол Улс шиг цөөхөн хүн амтай улсад өнөөгийн ажилгүйдлийн түвшин харьцангуй өндөр гэж хэлж болно. Учир нь 2016 онд барилгын болон боловсруулах, эрчим хүчний салбарын үйлдвэрлэл эрчимтэй буурч эдгээр салбарт ажиллагчдын тоо 16,7 мянган хүнээр буурч төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нэмэгдээгүй нь хүн амын амьжиргаанд сөргөөр нөлөөлж ядуурлын түвшинг бууруулахад нөлөөлсөн байна.

¹ Joseph E. Stiglitz, Globalization and it's discontents. 2003.

Дэлхийн Банктай хамтран Үндэсний статистикийн хорооноос хийсэн ядуурлын судалгаанд Монгол улсын ядуурлын түвшин 2014 онд 21,6 хувь байсан бол 2016 онд 29,6 хувьд хүрч 8,0 пунктээр өссөн гэж дурьдсан байна. Өөрөөр хэлбэл 2016 оны 3 сая хүнээс 907,5 мянган хүн нь ядууралд өртсөн байна гэсэн үг. Ядуурлын гүнзгийрэлт 2016 онд 7,7 хувь болж, 2014 оныхоос 2,5 пунктээр өссөн байна.

Хэдийгээр Монгол Улсын нийт хүн амд хөдөөгийн хүн амын эзлэх хувийн жин бага, хөдөө орон нутагт мал маллах боломж их байгаа ч гэсэн хотын хүн амтай харьцуулахад хөдөө орон нутагт ядуурал илүү нэмэгдсэн байна. Тухайлбал, 2012 оныхоос хөдөө орон нутагт ядуурлын түвшин 2014 онд 11,7 пунктээр буурсан байхад харин 2016 онд 10,1 пунктээр өссөн байна. Ядуурлын байдлыг аймгаар бүсчилж үзвэл Баруун бүсийн 4 аймгаас Увс аймгийн ядуурал хамгийн бага буюу хамралтын хүрээ нь 24,2 хувь, Завхан аймагт ядуурал хамгийн өндөр буюу хамралтын хүрээ нь 47,5 хувь байна. Хангайн бүсийн 5 аймгаас Орхон аймагт ядуурал хамгийн бага буюу хамралтын хүрээ нь 23,5 хувь, Өвөрхангай аймагт ядуурал хамгийн өндөр буюу хамралтын хүрээ нь 41,1 хувь байна. Төвийн бүсийн зургаан аймгаас Өмнөговь аймгийн ядуурал хамгийн бага буюу хамралтын хүрээ нь 15,4 хувь, харин Говьсүмбэр аймагт ядуурал хамгийн өндөр буюу хамралтын хүрээ нь 52,4 хувь байна. Харин Зүүн бүсийн 3 аймгийн ядуурлын хамралтын хүрээ ойролцоо буюу 41,5-47,0 хувь байна.

Дүгнэж хэлэхэд Монгол Улсын төр, засгийн зүгээс өнгөрсөн 28 жилд эдийн засгийн салбарт хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтыг онолын талаас судлаж үзвэл хэтэрхий үрэлгэн, шинжлэх ухааны тооцоо судалгаа дээр суурилагагүй, өмнөх засгийн газрын хэрэгжүүлж байсан ажлыг үрэлжлүүлж, сайжруулсан залгамж шинж чанаргүй, улс орны нийгэм, эдийн засгийн өвөрмөц онцлогыг тооцоогүй, үндэсний язгуур эрх ашиг гэхээсээ илүү гадны эрх ашгийг хамгаалсан гэж хэлж болохоор байна. Өөрөөр хэлбэл, барууны орнууд болон олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудын зүгээс хөгжиж байгаа улс орнуудад тулгадаг неолиберал бодлоготой адилхан байна. Энэхүү бодлогын үр дүнд бид дотоод зах зээлээ хэтэрхий нээлтэй ямар ч хамгаалалтгүй болгож, боловсруулах аж үйлдвэрүүдээ устгаж, гадаад зах зээлийн хэт хамааралтай болгож чаджээ. Ингэснээр ажилгүйдэл,

ядуурал, өр, зээл цэцэглэх болж, улмаар нийгмийн бухимдал газар авах шалтгаан болжээ. Үүний үндсэн шалтгааныг гаднаас биш дотоодоос хайх хэрэгтэй байх гэж бодож байна.

Хөгжлийн өндөр түвшинд хүрч чадсан Зүүн Азийн зарим орнуудын туршлагаас харахад төрийн эдийн засгийн хөгжлийн бодлого нь өөрийн орны эдийн засгийн хүчин чадал, багтаамж, нөөц, газар зүйн байршилт, байгаль цаг агаарын нөхцөл, иргэдийнхээ ахуй амьдрал, сэтгэлгээ, түүх, соёл, уламжлал, зан заншил зэрэг өвөрмөц онцлогуудыг сайтар харгалзан үзэж, ард түмнийхээ язгуур эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ирсэнийг цохон тэмдэглэмээр байна. Эдгээр алдаг ойлгож, засаж залруулахад дараах асуудлыг шийдэх шаардлагатай гэж бодож байна. Үүнд:

- Өнгөрсөн 28 жилийн туршид тус улсын нийгэм, эдийн, засаг, улс төрийн зэрэг бүх салбарт хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаанд шинжилгээ хийж, улс төрийн дүгнэлт гаргах, цаашид алс хэтийн хөгжлийнхөө чиг хандлагыг тодорхойлохын тулд “неолиберал онолыг Монгол Улс хэрэгжүүлсэний үр дагавар” сэдвээр бүх нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Улс орны онцлог нөхцөл байдлыг харгалзсан, үндэсний язгуур эрх ашгаа нэн тэргүүнд тавьсан Монгол Улсын хөгжлийн бодлогын онол, арга зүйн үзэл баримтлалыг шинээр томъёолох, зарим олон улсын байгууллага, тухайлбал, ДХБ-тай байгуулсан гэрээ хэлэлцээрийн хүрээнд гадаад худалдааг хөнгөлөвчлөх арга хэмжээнүүдээс хөгжиж байгаа орны эдлэх ёстой хөнгөлөлтийн эрхийг эдлэх, ОХУ, БНХАУ гэсэн хөрш орнуудтай худалдааны салбарт байгуулсан хоёр талт хэлэлцээрүүдийг шинэчлэх, тэгш эрхтэй худалдааг зохион байгуулах;
- Монгол Улс урт хугацааны хөгжлийн бодлого, үйл ажиллагаандаа үндэсний боловсруулах аж үйлдвэрээ сэргээн хөгжүүлэх зорилтыг тавьж неолиберал бодлогоос татгалзах, үндэсний үйлдвэрлэлээ төрөөс хамгаалах зорилгоор дотооддоо чөлөөт эдийн засгийн бодлого, гадаадад

протекционист бодлого хэрэгжүүлэх;

- Дээрх арга хэмжээний хүрээнд нэн тэргүүнд төрөөс өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй эх орны үйлдвэрүүдэд өмчийн хэлбэр харгалзахгүй захиргааны болон захиргааны бус дэмжлэг, туслалцаа үзүүлэх, татаас олгох, татварын болон зээлийн хөнгөлөлт үзүүлэх замаар экспортыг урашуулах, импортыг оновчтой уян хатан үе шаттай хязгаарлах (тарифын болон тарифын бус хязгаарлалт, олон зорилго чиглэлтэй стандартууд, лиценз, квотууд) тогтоох шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Joseph E. Stiglitz, Globalization and it's discontents. 2003.
2. Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <https://www.nso.mn>
3. Үндэсний статистикийн хорооны мал тооллогын 2017 оны урьдчилсан дүн, <https://www.nso.mn>
4. Монгол банкны мэдээллийн нэгдсэн сайт, <https://www.mongolbank.mn/>
5. Дэлхийн Банкны ядуурлын судалгааны тайлан, <http://www.worldbank.org/mn/news/press-release/2017/10/17/2016-poverty-rate-in-mongolia-estimated-at-296-percent>
6. Үндэсний статистикийн хорооны 2017 оны 12 сарын товхимол, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2017 оны урьдчилсан гүйцэтгэл, <https://www.nso.mn>

АЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗАГВАРЫН ТУХАЙД БОДРОЛ

A Some Thought Regarding Asian Development Model

Др.проф. Д.Уламбаяр¹
ulambayar@humanities.mn

ХӨГЖЛИЙН МОДЕЛИЙН ТУХАЙД

Хүн төрөлхтөн өнөөгийн ирмүүн хөгжлийн өндөрлөгт тулж ирэхдээ улс төр-эдийн засаг, нийгмийн хөгжлийн үр ашиг бүхий хэд хэдэн загварыг буй болгож бүтээн байгуулж иржээ.

Нэг дэх нь Өрнө дахиний хөгжингүй орнуудын эдийн засгийн хөгжлийн загвар даруй мөн бөгөөд энэ нь 1640 оны Английн Хөрөнгөтний аугаа их хувьсгалаар гараагаа эхэлж, 1760-1820 онд өрнөсөн аж үйлдвэрийн хувьсгал, 1776 оны Америкийн Тусгаар тогтнолын Тунхаглал, 1787 оны Америкийн Анхдугаар Үндсэн хууль, 1789 оны Францын Хөрөнгөтний их хувьсгал, түүний үр дүнд батлагдсан Хүн ба Иргэний Эрхийн Тунхаглал, 1791 оны АНУ-ын Эрхзүйн Тунхаглал, 1865 онд Америкийн иргэнийн дайны үр дүнд боолчлолыг ялсан Хөрөнгөтний хоёр дахь хувьсгалаар бэлтгэгдэж өнөөг хүрч ирсэн буюу **улс төрийн ардчилалыг хөгжүүлэх үндсэн дээр эдийн засгийн ардчилалыг хөгжүүлж ирсэн тэр загвар** юм. Сонгох, сонгогдох, үг хэлэх, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, жагсаал цуглаан зохион байгуулах, өмч эзэмших, түүнийг захиран зарцуулах, бизнес эрхлэх, чөлөөтэй зорчих, шүүхэд дуудагдахад өмгөөлөл авах болон бусад хүний эн тэргүүний эрхийг хуульчилсан нь зах зээлийн эдийн засаг өөрийн жам ёсоороо хөгжин

¹ Д.Уламбаяр. ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал